

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99041524 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.15 № 118

танай _____ -ны № _____ -т

ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.БАТЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд 24,240.3 мянган төгрөгийн урсгал засварын материал, 103,302.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн,
- Авто замын нөхөөс хийх 78,000.0 мянган төгрөгийн, урсгал засварын 42,400.0 мянган төгрөгийн ажлын төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн,
- Албан хаагчдад төсөвт тусгаагүй 128,041.6 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгосон,
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин бараа үйлчилгээний бусад зардлаас баяр наадмын зардалд 4,727.5 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан,

822511000356

- Албан хаагчдад хууль тогтоомжид заагаагүй 5,800.0 мянган төгрөгийн тэтгэмж, сахилгын шийтгэлтэй албан хаагчид 641.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,
- Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2018, 2020, 2023, 2024, 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн цалингийн нөхөн олговор болон авлагын үлэгдэлтэй холбоотой 83,940.1 мянган төгрөгийн албан шаардлага, 2023, 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 46,187.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.2 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Шинээр тавигдах 15.6 километр авто замын газар чөлөөлөлтийн ажилтай холбоотойгоор 166,717.1 мянган төгрөг, Засагт ханы хот айл хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд 54,845.1 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан, өмнөх онуудад сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр бий болсон 3,891,357.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн төсвийн санхүүжилтийг 5,881,561.0 мянган төгрөгөөр баталж, өмнөх оноос 219,423.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Бусад асуудал

Тайлант онд 7 зорилт, 248 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 193 арга хэмжээ нь 85 хувиас дээш хэрэгжилттэй буюу бүрэн хангалттай, 38 арга хэмжээг 70-85 хувь буюу хангалттай, 17 арга хэмжээ 70 хувь хүртэл буюу хангалтгүй, нийт дүнгээр 94 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г. ГҮНЖИДМАА

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	310,074,554.83	192,371,065.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,082,568.83	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		39,864,265.00
335	Бусад авлага	306,991,986.00	152,506,800.00
33510	Байгууллагаас авах авлага	202,927,186.00	81,200,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	104,064,800.00	71,306,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	188,294,215.79	100,861,215.79
354	Хангамжийн материал	140,994,215.79	53,561,215.79
35410	Бичиг хэргийн материал	3,400,510.00	4,015,510.00
35420	Аж ахуйн материал	36,908,705.79	36,908,705.79
35450	Барилгын засварын материал	7,330,000.00	7,330,000.00
35470	Бусад хангамжийн материал	93,355,000.00	5,307,000.00
35600	Мал амьтад	47,300,000.00	47,300,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	19,900,000.00	40,396,000.00
36300	Тэжээлийн нөөц	19,900,000.00	40,396,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	518,268,770.62	333,628,280.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,072,990,326.45	6,846,759,545.91
39100	Газар		
392	Биет хөрөнгө	1,960,864,669.25	6,739,214,731.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,691,618.32	760,691,618.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(198,087,944.06)	(228,674,796.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	421,713,800.00	93,619,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(101,554,800.16)	(54,325,900.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,243,148,191.90	1,121,885,465.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(679,318,202.36)	(741,279,946.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	116,300,150.00	132,683,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,792,450.61)	(65,159,442.87)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	822,701,710.16	6,251,726,069.16
39215	Хуримтлагдсан элэгдэл	(367,937,403.94)	(541,950,735.81)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	112,125,657.20	107,544,814.40
39301	Програм хангамж	2,640,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,640,000.00)	(1,800,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	116,706,500.00	116,706,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(4,580,842.80)	(9,161,685.60)
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,072,990,326.45	6,846,759,545.91
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,591,259,097.07	7,180,387,826.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,106,700.00	0.00
413	Өглөг	4,106,700.00	0.00
4136	Бусад өглөг	4,106,700.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,106,700.00	0.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,106,700.00	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,587,152,397.07	7,180,387,826.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	379,938,538.67	379,938,538.67
511001	Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан	379,938,538.67	379,938,538.67
512	Хуримтлагдсан үр дүн	1,544,050,300.20	6,148,696,840.94
51210	Өмнөх үеийн үр дүн	764,593,281.51	4,750,320,443.08
51220	Тайлант үеийн үр дүн	779,457,018.69	1,398,376,397.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	663,163,558.20	651,752,447.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,587,152,397.07	7,180,387,826.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,591,259,097.07	7,180,387,826.70



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	5,896,453,217.00	6,015,437,504.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,316,017.00	125,189,377.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,750,517.00	124,979,377.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,565,500.00	210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,762,137,200.00	5,890,248,127.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,762,137,200.00	5,890,248,127.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	460,170,075.00	2,660,061,382.33
120	Нийтлэг татварын бус орлого	460,170,075.00	2,660,061,382.33
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	369,858,075.00	2,658,541,382.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	90,312,000.00	1,520,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,356,623,292.00	8,675,498,886.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,329,178,809.39	6,474,540,177.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,973,186,828.72	6,374,607,508.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,544,054,627.21	1,691,306,855.82
210101	Үндсэн цалин	933,238,088.42	1,004,448,419.17
210102	Нэмэгдэл	401,399,959.72	437,923,567.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,421,111.06	128,041,630.80
210104	Урамшуулал	128,995,468.01	94,643,238.61
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	26,250,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,347,188.46	246,562,100.00
210201	Тэтгэврийн даатгал	127,279,691.66	184,622,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,705,824.20	15,480,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,252,612.10	7,749,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,502,612.10	7,749,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,606,448.40	30,959,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,418,911.55	106,109,340.25
210301	Гэрэл, цахилгаан	13,719,828.09	23,783,632.95
210302	Түлш, халаалт	70,989,427.46	74,963,766.30
210303	Цэвэр, бохир ус	9,709,656.00	7,361,941.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,477,974.02	136,978,698.02
210401	Бичиг хэрэг	9,909,400.00	6,787,050.00
210402	Тээвэр, шатахуун	42,772,100.00	23,521,800.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	8,423,966.02	9,332,868.02
210404	Ном, хэвлэл	0.00	220,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	990,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,652,508.00	5,969,980.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	0.00	90,157,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,818,892.00	78,651,296.00
210604	Урсгал засвар	33,818,892.00	78,651,296.00
2107	Томилолт, зочны зардал	26,825,150.00	45,411,241.00
210701	Гадаад албан томилолт	0.00	15,000,000.00
210702	Дотоод албан томилолт	26,825,150.00	30,411,241.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,078,603.00	853,966,535.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	197,201,034.00	849,173,135.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,500.00	426,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	414,232.00	138,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,972,900.00	2,162,700.00
210807	Газрын төлбөр	403,937.00	2,000,000.00



Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,839,165,482.48	3,215,621,442.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,528,868,224.09	2,671,681,592.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,914,400.00	10,127,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	285,382,858.39	533,812,350.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	355,991,980.67	99,932,668.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,423,288.00	59,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	58,353,288.00	43,740,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,070,000.00	16,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,415,465.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19,415,465.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	242,153,227.67	40,032,668.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	242,153,227.67	40,032,668.89
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,988,400.00	0.00
2200	Догоод эх үүсвэрээр	94,988,400.00	0.00
223001	Бусад хөрөнгө	94,988,400.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,424,167,209.39	6,474,540,177.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	932,456,082.61	2,200,958,708.74
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	182,360,437.92	802,582,310.88
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	182,360,437.92	802,582,310.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(182,360,437.92)	(802,582,310.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	750,095,644.69	1,398,376,397.86



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,896,453,217.00	6,015,437,504.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,316,017.00	125,189,377.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	94,750,517.00	124,979,377.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,565,500.00	210,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,762,137,200.00	5,890,248,127.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,762,137,200.00	5,890,248,127.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	61,190,620.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	61,190,620.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,190,620.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,190,620.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,957,643,837.00	6,015,437,504.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,121,845,451.00	5,912,135,092.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,765,853,470.33	5,772,338,158.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,545,074,127.21	1,691,306,855.82
210101	Үндсэн цалин	934,257,588.42	1,004,448,419.17
210102	Нэмэгдэл	401,399,959.72	437,923,567.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,421,111.06	128,041,630.80
210104	Урамшуулал	128,995,468.01	94,643,238.61
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	26,250,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,347,188.46	246,562,100.00
210201	Тэтгэврийн даатгал	127,279,691.66	184,622,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,705,824.20	15,480,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,252,612.10	7,749,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,502,612.10	7,749,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,606,448.40	30,959,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,418,911.55	106,109,340.25
210301	Гэрэл, цахилгаан	13,719,828.09	23,783,632.95
210302	Түлш, халаалт	70,989,427.46	74,963,766.30
210303	Цэвэр, бохир ус	9,709,656.00	7,361,941.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,659,274.02	47,730,698.02
210401	Бичиг хэрэг	10,820,400.00	7,352,050.00
210402	Тээвэр, шатахуун	42,483,100.00	23,521,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,643,966.02	9,332,868.02
210404	Ном, хэвлэл	0.00	220,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	990,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,991,808.00	6,313,980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,494,892.00	78,979,296.00
210604	Урсгал засвар	43,494,892.00	78,979,296.00
2107	Томилолт, зочны зардал	26,825,150.00	45,411,241.00
210701	Гадаад албан томилолт	0.00	15,000,000.00
210702	Дотоод албан томилолт	26,825,150.00	30,411,241.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	266,978,603.00	856,162,535.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	264,101,034.00	851,369,135.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,500.00	426,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	414,232.00	138,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,972,900.00	2,162,700.00
210807	Газрын төлбөр	403,937.00	2,000,000.00

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,552,055,324.09	2,700,076,092.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,527,140,924.09	2,689,948,592.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,914,400.00	10,127,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	355,991,980.67	139,796,933.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,423,288.00	59,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	58,353,288.00	43,740,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,070,000.00	16,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,415,465.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19,415,465.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдал олгох татаас, санхүүжилт	242,153,227.67	79,896,933.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	242,153,227.67	40,032,668.89
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		39,864,265.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	5,121,845,451.00	5,912,135,092.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	835,798,386.00	103,302,411.50
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	835,798,386.00	103,302,411.50
2200	Дотоод эх үүсвэрээр	835,798,386.00	103,302,411.50
223001	Бусад хөрөнгө	715,201,986.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	120,596,400.00	103,302,411.50
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	835,798,386.00	103,302,411.50
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(835,798,386.00)	(103,302,411.50)
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,938,538.67	663,163,558.20	1,544,050,300.20	0.00	2,587,152,397.07
C11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	379,938,538.67	663,163,558.20	1,544,050,300.20	0.00	2,587,152,397.07
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	3,206,270,142.88	0.00	3,206,270,142.88
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	379,938,538.67	663,163,558.20	4,750,320,443.08	0.00	5,793,422,539.95
C14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	(11,411,111.11)	0.00	0.00	(11,411,111.11)
C15	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олд, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
C19	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	1,398,376,397.86	0.00	1,398,376,397.86
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,938,538.67	651,752,447.09	6,148,696,840.94	0.00	7,180,387,826.70



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,881,561,000.00	5,850,215,458.11	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,811,221,000.00	5,790,315,458.11	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,649,519,500.00	1,691,306,855.82	102.5
210101	Үндсэн цалин	737,703,800.00	1,004,448,419.17	136.2
210102	Нэмэгдэл	714,273,700.00	437,923,567.24	61.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	128,041,630.80	
210104	Урамшуулал	92,542,000.00	94,643,238.61	102.3
210105	Гэрээт ажлын хөлс	105,000,000.00	26,250,000.00	25.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,700,900.00	246,562,100.00	99.9
210201	Тэтгэврийн даатгал	184,681,800.00	184,622,100.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	15,504,800.00	15,480,500.00	99.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,752,400.00	7,749,800.00	100.0
210204	Ажилүйдлийн даатгал	7,752,400.00	7,749,800.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	31,009,500.00	30,959,900.00	99.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	112,118,000.00	106,109,340.25	94.6
210301	Гэрэл, цахилгаан	23,592,000.00	23,783,632.95	100.8
210302	Түлш, халаалт	78,635,000.00	74,963,766.30	95.3
210303	Цэвэр, бохир ус	9,891,000.00	7,361,941.00	74.4
2104	Хангамж, бараа материалын зардал	52,872,900.00	47,730,698.02	90.3
210401	Бичиг хэрэг	9,789,000.00	7,352,050.00	75.1
210402	Тээвэр, шатахуун	24,386,800.00	23,521,800.00	96.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,367,600.00	9,332,868.02	82.1
210404	Ном, хэвлэл	220,000.00	220,000.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,110,000.00	990,000.00	89.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,999,500.00	6,313,980.00	105.2
2105	Нормативт зардал	1,600,000.00	0.00	0.0
210502	Хоол, хүнс	1,600,000.00	0.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	128,838,000.00	123,619,196.00	95.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,739,000.00	24,739,900.00	49.7
210602	Тавилга	100,000.00	19,900,000.00	19900.0
210604	Урсгал засвар	78,999,000.00	78,979,296.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	45,461,000.00	45,411,241.00	99.9
210701	Гадаад албан томилолт	15,000,000.00	15,000,000.00	100.0
210702	Дотоод албан томилолт	30,461,000.00	30,411,241.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	871,040,900.00	848,250,735.00	97.4
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	865,427,800.00	842,637,635.00	97.4
210803	Даатгалын үйлчилгээ	426,700.00	426,700.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	138,000.00	138,000.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,982,400.00	2,982,400.00	100.0
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	2,000,000.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,703,069,800.00	2,681,325,292.02	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,684,867,800.00	2,671,197,792.02	99.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	18,202,000.00	10,127,500.00	55.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,340,000.00	59,900,000.00	85.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,340,000.00	59,900,000.00	85.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	45,000,000.00	43,740,000.00	97.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,340,000.00	16,160,000.00	63.8
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	5,881,561,000.00	5,850,215,458.11	99.5
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,881,561,000.00	5,850,215,458.11	99.5
320001	Орон нутгийн төсвөөс	5,881,561,000.00	5,850,215,458.11	99.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,189,377.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,189,377.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,325,112.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,660,500.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,660,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,664,612.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,664,612.0
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,864,265.0
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,864,265.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,189,377.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,189,377.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,979,377.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	210,000.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 85,264.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал 200.0 мянган төгрөгийг дутуу, тавилга дансанд 20,000.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- Татаас санхүүжилтийн авлага болох 39,864.3 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй,
- Төсвийн гүйцэтгэл хэлбэлзлээс 25,200.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнсныг залрууллаа.

Залруулагдаагүй нийт 547,183.9 мянган төгрөгийн зөрчлөөс сумын Засаг даргад 160,030.6 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг тус тус хүргүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитын дүгнэлтэд авч үзэхээр шийдвэрлэсэн.

Бусад 387,153.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар 387,153.3 мянган төгрөгийн 6 зөрчлөөс², 6,441.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 247,942.7 мянган төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцуулах, 4,727.5 мянган төгрөгийн 1 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах 128,041.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 641.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Албан хаагчдад хууль тогтоомжид заагаагүй 5,800.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" заалттай нийцэхгүй санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

1. Тайлант онд босго үнээс давсан 24,240.3 мянган төгрөгийн урсгал засварын материал, 103,302.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн, 78,000.0 мянган төгрөгийн авто замын нөхөөс хийх ажил, 42,400.0 мянган төгрөгийн урсгал засварын ажлын төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн, Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын өмнөх онуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн цалингийн нөхөн олговор болон авлагын үлэгдэлтэй холбоотой 2018 оны 03/49, 2020 оны 03/110, 2023 оны 03/139, 04/139, 2024 оны 03/74, 13/74, 2025 оны 07/190 дугаартай 83,940.1 мянган төгрөгийн албан шаардлага, 2023 оны 01/103, 04/103, 06/103, 02/103, 03/103, 07/103, 05/103, 2025 оны 03/101, 02/101 дугаартай 46,187.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг тус тус хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын даргад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.



3. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин бараа үйлчилгээний бусад зардлаас баяр наадмын зардалд 4,727.5 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын "Ангилал шинэчлэн батлах тухай" 2023 оны 211 дүгээр тушаалд заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардал гаргадаг байдлыг таслан зогсоох.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Албан хаагчдад төсөвт тусгаагүй 128,041.6 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоотой хийж батлуулан ажиллагсадтай холбоотой зардлыг төсөвт тусгасны дагуу олгох, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар	Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал 200.0 мянган төгрөгийг ДУУУ, тавилга дансанд 20,000.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Төсвийн гүйцэтгэл хэлбэлзлээс 25,200.0 мянган төгрөгөөр зөрүүтэй Татаас санхүүжилтийн авлага болох 39,864.3 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй.	1	20,200.0	-	-	1	20,200.0	1	20,200.0	-	-	-	-
	Дүн	3	85,264.3	1	39,864.3	2	45,400.0	2	45,400.0	-	-	-	-



Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2 Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын өмнөх онуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн цалингийн нөхөн олговор болон авлагын үлэгдэлтэй холбоотой 2018 оны 03/49, 2020 оны 03/110, 2023 оны 03/139, 04/139, 2024 оны 03/74, 13/74, 2025 оны 07/190 дугаартай 83,940.1 мянган төгрөгийн албан шаардлага, 2023 оны 01/103, 04/103, 06/103, 02/103, 03/103, 07/103, 05/103, 2025 оны 03/101, 02/101 дугаартай 46,187.2 мянган төгрөгийн төлбөрийн актыг тус тус хэрэгжүүлээгүй байна.	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар	Зардлын эдийн засгийн ангилал зөрчин бараа үйлчилгээний бусад зардлаас баяр наадмын зардалд 4,727.5 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан. Албан хаагчдад төсөвт тусгаагүй 128,041.6 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгосон. Тайлант онд босго үнээс давсан 24,240.3 мянган төгрөгийн урсгал засварын материал, үндсэн 103,302.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн, 78,000.0 мянган төгрөгийн авто замын нөхөөс хийх ажил, 42,400.0 мянган төгрөгийн урсгал засварын ажлын төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн. Албан хаагчдад хууль тогтоомжид заагаагүй 5,800.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон. Сахилгын шийтгэлтэй албан хаагчид 641.5 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	1	4,727.5	-	-	1	4,727.5	-	-	1	-	-
	Дүн	6	387,153.3	2	6,441.5	1	4,727.5	1	128,041.6	2	247,942.7	



Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		

